



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 07 сарын 22 өдөр

Дугаар 285

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө бүртгэх зөвшөөрөл
олгох тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 25 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2008 оны “Төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах арга хэмжээний тухай” 148 дугаар тогтоолын 1.а дахь заалт, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан “Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам”-ын 4.3, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 35кВ-ын цахилгаан дамжуулах агаарын шугам, 35/15кВ-ын дэд станц өргөтгөлийн ажлын хүрээнд бий болсон Баянхонгор аймгийн Баянлиг-Шинэжинст сумын нутаг дэвсгэрт байрлалтай, нийт 3,623,678,688.00 (гурван тэрбум зургаан зуун хорин гурван сая зургаан зуун далан найман мянга зургаан зуун наян найман) төгрөгийн балансын үнэ, 410,110,152.00 (дөрвөн зуун арван сая нэг зуун арван мянга нэг зуун тавин хоёр) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан хөрөнгийг “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанид эзэмшүүлсүгэй.

2. Эрчим хүчний яамны Төрийн нарийн бичгийн дарга З.Мэндсайхан, “Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ” төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал Г.Баярцогт нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Комисс томилон хөрөнгө хүлээн авч бүртгэх ажлыг байгууллагын өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, “Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем”-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 4 дүгээр улиралд багтаан ирүүлэх.


3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД


ТӨРИЙН ӨМЧИЙН БҮРТГЭЛ,
ХЯНАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



000052

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтыг
2019 оны 07 дугаар сарын 23-ны
ХХЗ дугаар тогтоолын



**"Эрдэнэт Булганы цахилгаан түгээх сүлжээ" төрийн өмчит хувьцаат компанийн
дансанд бүртгэх барилга байгууламжийн жагсаалт**

Байгууламжийн нэр,	Хэмж их нэгж	Тоо	Захиалагч байгууллага	Гүйцэтгэгч байгууллага	Гэрээний дугаар	Улсын комиссын акт дугаар	Төсөвт өртөг (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл (төгрөг)
Баянлиг-Шинэжинст	ш	1	ЭХХТ	"Виваланд" ХХК	12/54	2017.08.30 10/2017	3,134,469,269.00	352,627,793.00	2,781,841,475.00
Шинэжинст" дэд	ш	1	ЭХХТ	"Виваланд" ХХК	12/54	2017.08.30 10/2017	355,535,391.00	39,997,732.00	315,537,659.00
Баянлиг" дэд төл	ш	1	ЭХХТ	"Виваланд" ХХК	12/54	2017.08.30 10/2017	68,439,362.00	7,699,428.00	60,739,934.00
Эжинст ЦДАШ	ш	1	ЭХХТ	"Виваланд" ХХК	12/54	2017.08.30 10/2017	27,343,610.00	4,101,541.00	23,242,069.00
Улаанбаатар 15/0.4 кВ-ын Т-1 1х160кВА	ш	1	ЭХХТ	"Виваланд" ХХК	12/54	2017.08.30 10/2017	20,840,081.00	3,126,012.00	17,714,069.00
Улаанбаатар 15/0.4 кВ-ын Т-2 1х100кВА	ш	1	ЭХХТ	"Виваланд" ХХК	12/54	2017.08.30 10/2017	17,050,975.00	2,557,646.00	14,493,329.00
							3,623,678,688.00 (гурван тэрбум зургаан зуун хорин гурван сая зургаан зуун далан найман мянга зургаан зуун наян найман)	410,110,152.00 (дөрвөн зуун арван сая нэг зуун арван мянга нэг зуун тавин хоёр)	3,213,568,536.00 (гурван хоёр зуун гурван сая зурван зуун наймн таван зуун зургаан)